



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, Эрх чөлөөний өргөн чөлөө-3,
Уртбулаг баг, Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61033

Утас: (976) 7035 9826

Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2026.02.02 № 42
танай -ны № -т

2025 оны санхүүгийн тайлангийн аудитын тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д заасан бүрэн эрхийн хүрээнд Орхон аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг түүвэрт хамруулан, баталгаажуулах аудит хийлээ.

Аудитаар нийт 7,906.2 мянган төгрөгийн зөрчил илэрч, аудитаар илрүүлсэн зөрчлийн асуудлын бүртгэл хөтлөн баталгаажуулж, 776.0 мянган төгрөгийн зөрчилт төлбөрийн акт тогтоож, 6,000.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, өр төлбөр үүсгэхгүй байхад анхаарч ажиллах талаар 1 зөвлөмж өгч байна. Үүнд:

Төлбөрийн акт:

Илрүүлэлт 1: Байгууллагын албан хаагчдын томилолтой болон цалинтай чөлөөтэй хугацаанд 776.0 мянган төгрөгийн хоолны хөнгөлөлтийг давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 2.4-д "Албан томилолтоор ажилласан хоногийн тоог албан томилолтоор ажиллуулах шийдвэрт тэмдэглэсэн хуанлийн хоногоор тооцож гаргана. Албан томилолтоор явсан, буцаж ирсэн өдрийг нэгтгэн нэг хоногт тооцно", 2.2-д "Албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр дараах зардлаас бүрдэнэ", 2.2.1-д "унааны зардал", 2.2.2-д "байрны зардал", 2.2.3-д "хоолны зардал" гэж заасныг зөрчсөн байна.

Албан шаардлага:

Илрүүлэлт 1: Гэрээгээр ажил үйлчилгээ гүйцэтгэсэн ажлын хөлс 6,000.0 мянган төгрөгийг цалингийн зардлаас зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж,

612505091

зарцуулах", 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.3-д "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох;", Сангийн сайдын 2023 оны "Төсийн зарим ангилал шинэчлэн батлах тухай" 211 дугаар тушаалын хавсралтаар баталсан тушаалыг мөрдөн ажиллаагүй байна.

Зөвлөмж:

Илрүүлэлт 1: Тайланд онд албан хаагчдад томилолтын 1,103.2 мянган төгрөгийн өглөг үүсгэн ажилласан байна.

Төсвийн тухай хуулийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.", 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийг зохистой удирдаж, өр төлбөр үүсгэхгүй байх.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ." гэж заасныг хэрэгжүүлж төлбөрийн акт, албан шаардлагын мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 30 хоногийн дотор, төлбөрийн актыг бүрэн барагдуулж, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П.ПҮРЭВЛХАГВА